

**ХОРИГДЛЫГ СУЛЛАГДАХАД БЭЛТГЭХЭД “САЙН ДУРЫН
АЖИЛТАН”-ЫГ ОРОЛЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ОЛОН
УЛСЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ СУДЛАХ НЬ**

**STUDYING THE LEGAL BASIS AND INTERNATIONAL PROGRAMS
FOR THE INVOLVEMENT OF “VOLUNTEER WORKERS” IN
PREPARING PRISONERS FOR RELEASE**



Г.Батжаргал

*ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш,
хошууч*

Товч утга: Нийгмийн эмзэг болон зорилтот бүлгийн өмнө тулгардаг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн байгууллага, төвүүд нь ихэвчлэн хүний нөөц, санхүүгийн дутмаг байдалтай тулгардаг. Иймээс эдгээр байгууллагууд хязгаарлагдмал нөөцөө үр дүнтэй удирдахын тулд сайн дурынхны оролцоог чухалчилж, тэдний туслалцааг эрэлхийлэх шаардлагатай болдог. Гэсэн хэдий ч зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйл ажиллагаа, үйлчилгээ нь иргэдийн сэтгэл ханамжийг төдийлөн хангаж чаддаггүй.

Үүний шалтгаан нь сайн дурынхны оролцоог хангах, тэдний чадавхыг зөв зохистой ашиглах талаарх төрийн байгууллагуудын мэдээлэл дутмаг байдал болон сайн дурын үйл ажиллагааны талаарх нийгмийн ойлголт, хандлага төдийлөн өөрчлөгдөхгүй байгаатай холбоотой юм.

Түлхүүр үгс: Сайн дурын ажил, хоригдлыг нийгэмшүүлэх, нийгмийн халамж, хүний нөөц, иргэний оролцоо.

Abstract: Social welfare organizations and centers that address the problems faced by vulnerable and target groups in society often face a lack of human and financial resources. Therefore, these organizations need to prioritize the participation of volunteers and seek their assistance in order to effectively manage their limited resources. However, government activities and services aimed at target groups do not meet the satisfaction of citizens.

The reason for this is the lack of attention of government organizations to ensure the participation of volunteers and the proper use of their potential, and the lack of significant changes in social understanding and attitudes towards volunteering.

Key words: Volunteerism, Re-socialization of prisoners, Social welfare, Human resources, Civic engagement.

УДИРТГАЛ

Орчин үеийн нийгмийн хөгжил дэвшлийн үндэс нь иргэдийн идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлаж байна. Энэ утгаараа сайн дурын ажил нь хувь хүний нийгмийн хариуцлага, энэрэнгүй сэтгэл, эв нэгдлийг илэрхийлсэн, олон нийтийн сайн сайхны төлөө чиглэсэн чухал үнэт зүйл болон төлөвшжээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей сайн дурын ажлыг улс орнуудын нийгмийн чадавх, уян хатан байдлыг дэмжих үндсэн эх үүсвэр хэмээн томьёолж, жил бүрийн арван хоёрдугаар сарын 5-ны өдрийг "Олон улсын сайн дурынхны өдөр" болгон тэмдэглэж байна.

Сайн дурын хөдөлгөөний тухай ойлголт нь түүхийн хөгжлийн явцад өөрчлөгдөж, баяжсаар ирсэн бөгөөд анх цэргийн холбоотой нэр томьёоноос гаралтай байсан бол өнөөдөр халамжийн үйлчилгээнд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж буй нийгмийн хүчин зүйл болсон байна. Япон, Солонгос, Америк¹ зэрэг улс орнуудын сайн дурынхны талаарх тодорхойлолтуудаас үзэхэд сайн дурын ажил нь зөвхөн бусдад туслах төдийгүй өөрийгөө хөгжүүлэх, туршлага хуримтлуулах, хамтын үнэт зүйлсийг бүтээх боломжийг олгодог иж бүрэн үйл явц юм.

Манай улсын нийгмийн тусламж дэмжлэгийн өнөөгийн тогтолцоог дүрслэн харвал: төрийн оролцооны хувь хэмжээ өндөр боловч орон нутгийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог харьцангуй бага байна. Энэ

¹ Америкийн "Нийгмийн ажлын тайлбар толь"-д "Сайн дурынхны хөдөлгөөнд оролцох хүсэлтэй хүмүүсийг тодорхой хугацааны сургалтад хамруулсны дараа сайн дурынхан гэж үзнэ" хэмээн тайлбарладаг. Өөрөөр хэлбэл тодорхой хугацааны сургалтад хамрагдаагүй бол сайн дурын ажилтан биш гэж үздэг.

Харин Солонгосын Нийгмийн халамжийн нийгэмлэгээс тодорхойлсноор "сайн дурынхан гэдэг нь нийгмийн асуудлаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй ажилд сайн дураараа оролцож ямар нэгэн хөлсгүйгээр хүмүүнлэг ардчилсан үзэл санаанд тулгуурлаж шаардлагатай үйлчилгээг үзүүлж оролцогчдыг хэлнэ" хэмээн тодорхойлсон байдаг. (Ким Бом Сү.2015)

Японы Осака хотод болсон олон улсын Филантропийн нийгэмлэгийн чуулганаар (1993 он) Сайн дурынхны хөдөлгөөн сайн дурын, халамжийн, хөлс мөнгөгүй, залгамж холбоотой зэрэг шинжүүдээр тодорхойлсон байна.

нь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар гурвалжны бүтцийг бий болгож, сайн дурынхны хөдөлгөөнд тулгуурлах шаардлагатай байгааг илтгэнэ.



ҮНДСЭН ХЭСЭГ

Сайн дурынхны хөдөлгөөнийг нийгмийн үйлчилгээнд ашиглах нь хэд хэдэн ач холбогдолтой. (Б.Сүх-Очир, 2015). Үүнд:

- Үйлчлүүлэгчдэд асуудлаа шийдэх сэдэл төрүүлэх, бие биеэсээ суралцах, тэдний оролцоог дэмжих
- Үйлчилгээний хүрээ болон далайцыг өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн ажлыг явуулах
- Мэргэжлийн итгэл үнэмшилтэй, мэдлэг, чадвар, хандлагатай нийгмийн ажилтнуудыг бэлтгэх сургалтын арга болгон ашиглах
- Төрийн оролцоог багасгаж, олон нийтийн, мэргэжлийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх
- Санхүүгийн зардлыг багасгаж, нөөц боломжоо ашиглах зэргийг онцолж болно.

Манай улсад залуучуудын нийгмийн оролцооны чухал хэлбэр нь сайн дурын ажил юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалаар "сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам"-ыг батлан хэрэгжүүлж байна. Тус журам нь сайн дурын ажил хийсэн, оролцсон тухай мэдээллийг бүртгэн баталгаажуулж, ажлын туршлагад тооцох боломж олгож байгаа нь залуучуудын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Мөн “төрийн албаны тусгай шалгалт”-ын удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадварын үнэлгээнд сайн дурын ажилтнуудын оролцсон

давуу талыг тооцож, төрийн албанд ажиллах сонирхолтой залуучуудад дэмжлэг үзүүлдэг болсон нь ач холбогдолтой.

Манай улсын хуулийн болон нийгмийн бүхий л салбар нь хүний хөгжлийг, нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлж, хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг бий болгоход чиглэж байна. 2017 онд шинэчлэгдсэн ШШГТХ-д нийгэмшүүлэх ажил, нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт гэсэн тусгай зохицуулалт тусгагдсан. Тухайлбал, энэ хууль нь хоригдлын нийгмийн харилцаанд оролцоог дэмжих, чадавхжуулах зорилготой бөгөөд энэ ажлыг зохион байгуулахад сайн дурын ажилтнууд оролцох шаардлагатай.

Олон улсын жишиг, туршлагад үндэслэн, Монгол Улсад хоригдлыг суллагдахад бэлтгэх, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд сайн дурын ажилтнуудын оролцоо нь нийгмийн тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл болдог. Сайн дурын ажилтнууд хоригдлуудын ёс суртахуун, сэтгэл зүй, боловсролд эерэг өөрчлөлт хийж, тэднийг нийгэмд дахин оролцох боломжийг нэмэгдүүлдэг нь дараах хөтөлбөрүүдээс харагдаж байна.

San Quentin-ийн "Puppy Program" (АНУ) Калифорни мужийн Сан Квентины хорих ангид хэрэгжиж буй энэхүү хөтөлбөрт хоригдлууд 16 сарын хугацаанд нохой сургаж, тэднийг үйлчилгээний нохой болгон бэлтгэдэг. Сайн дурын ажилтнууд нь нохойнуудын сургалтыг удирдан, хоригдлуудын сэтгэл зүй, хариуцлагын мэдрэмжийг сайжруулдаг. Хөтөлбөрт оролцсон хоригдлууд суллагдсаны дараа нийгэмд амжилттай нэгдэх, ажил эрхлэх боломжоо нэмэгдүүлсэн.² (<https://canine.org/news/>, 2023)

Inside-Out Prison Exchange Program (Inside-Out Prison Exchange Program) нь АНУ-ын Филадельфи хотод байрладаг Temple University-ийн Inside-Out Center төвд төвлөрсөн, хорих байгууллагад болон түүнээс гадуур суралцагчдыг хамарсан боловсролын хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь 1997 онд Temple University-ийн профессор Лори Помпа (Lori Pompa)-гийн санаачилгаар эхэлсэн бөгөөд хэтэрхий ялгаатай нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцан ойлголцлыг бий болгох зорилготой юм. Inside-Out хөтөлбөр нь хоригдлууд болон их дээд сургуулийн оюутнуудыг хамтад нь нэг семестрийн хугацаанд суралцуулдаг. Оюутнууд хоёуланд нь ижил

хөтөлбөрийн дагуу суралцаж, гэмт хэрэг, шүүхийн тогтолцоо, ял шийтгэл, нийгмийн шударга ёс зэрэг сэдвүүдээр хамтран ярилцаж, суралцдаг. Энэхүү арга барил нь харилцан ойлголцол, эмпат, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгддэг.

Inside-Out хөтөлбөр нь АНУ-ын 50 мужийн 150 гаруй их дээд сургуулиуд болон дэлхийн 15 оронд хэрэгжиж байна. Эдгээр хөтөлбөрүүд нь гэмт хэрэг судлал, сэтгэл судлал, нийгмийн ажил, жендэр судлал, түүх, философи зэрэг олон төрлийн мэргэжлийн чиглэлээр хичээллэдэг. (insideoutcenter.org, 2023)

Монгол Улсад Inside-Out хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь нийгмийн шударга ёс, хүний эрх, боловсролын хүртээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой байж болох юм. Хөтөлбөрийн бүтэц, арга барил нь Монголын боловсролын тогтолцоонд шинэ санаа, туршлага нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулж чадна.

Alternatives to Violence Project (Дэлхий даяар) Энэхүү хөтөлбөр нь хүчирхийлэлтэй тэмцэх, харилцааны ур чадварыг хөгжүүлэх зорилгоор хоригдлууд болон сайн дурын ажилтнуудыг хамруулан сургалт явуулдаг. Сайн дурын ажилтнууд нь сургалтын агуулгыг удирдан, хоригдлуудын сэтгэл зүй, хандлагад эерэг өөрчлөлт авчирдаг.

Prison Fellowship Academy (АНУ) Prison Fellowship Academy нь хоригдлуудад амьдралын ур чадвар, ёс зүй, гэр бүлийн харилцаа зэрэг сэдвээр сургалт явуулдаг. Сайн дурын ажилтнууд нь сургалтыг удирдан, хоригдлуудын сэтгэл зүй, хандлагад эерэг өөрчлөлт авчирдаг. (<https://www.prisonfellowship.org/>, 2024)

The Copper Project (Их Британи) Энэхүү төсөл нь хоригдлууд болон сайн дурын ажилтнуудын хамтын ажиллагааг дэмжих, нийгэмд оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Сайн дурын ажилтнууд нь хоригдлуудын нийгмийн оролцоог дэмжих, тэдний нийгэмшилд туслах үүрэг гүйцэтгэдэг. (<https://www.cep-probation.org/projects/>, 2025)

Yellow Ribbon Singapore (Сингапур) "Yellow Ribbon Singapore" хөтөлбөр нь хоригдлуудын нийгэмд дахин орох үйл явцыг дэмжих зорилготой бөгөөд сайн дурын ажилтнуудыг оролцуулдаг. Энэхүү хөтөлбөр нь хоригдлуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, ажлын байртай болох, нийгэмд дахин орох боломжийг нэмэгдүүлэх зорилготой олон төрлийн сургалт, ажлын байрны тусалцаа, нийгмийн оролцооны

хөтөлбөрүүдийг санал болгодог. Сайн дурын ажилтнууд нь хобби хичээлүүд, хэлний сургалт, компьютерын хэрэглээ, ярилцлагын ур чадвар зэрэг хичээлүүдийг хоригдлуудад зааж өгдөг. Эдгээр үйл ажиллагаа нь хоригдлуудын нийгэмд дахин орох үйл явцыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. (Singapore, 2024)

CSD Rehabilitation Volunteer Group (Гонконг) 2004 онд байгуулагдсан бөгөөд сайн дурын ажилтнуудыг хоригдлуудын сэтгэл зүй, ур чадварыг хөгжүүлэхэд оролцуулдаг. Энэхүү хөтөлбөр нь хобби хичээлүүд, хэлний сургалт, спортын үйл ажиллагаа, урлагийн хичээлүүдийг хоригдлуудад санал болгодог. Сайн дурын ажилтнууд нь хоригдлуудтай хамтран ажиллаж, тэдний нийгэмд дахин орох үйл явцыг дэмждэг. (www.csd.gov.hk, 2022)

Yokkao Redemption (Тайланд) "YOKKAO Redemption" хөтөлбөр нь хоригдлуудад Муай Тай боксын сургалт санал болгодог бөгөөд энэ нь тэдний сахилга бат, хариуцлагыг хөгжүүлэхэд тусалдаг. Хоригдлууд нь Муай Тай боксын өндөр түвшний сургалтад хамрагдаж, нийгэмд дахин орох боломжийг нэмэгдүүлдэг. Энэхүү хөтөлбөр нь хоригдлуудын хувийн хөгжлийг дэмжихээс гадна, тэдний нийгэмд дахин орох үйл явцыг хурдасгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. (asia.yokkao.com, 2025)

Srijan хөтөлбөр (Энэтхэг) "SRIJAN" хөтөлбөр нь хоригдлуудад гар урлал, цахилгаан, модон эдлэл үйлдвэрлэх зэрэг ур чадваруудыг зааж өгдөг. Энэхүү хөтөлбөр нь хоригдлуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, тэднийг нийгэмд дахин орох боломжийг нэмэгдүүлэх зорилготой. Сайн дурын ажилтнууд нь хоригдлуудтай хамтран ажиллаж, тэдний ур чадварыг хөгжүүлэхэд тусалдаг. (www.artofliving.org, 2024)

Эдгээр олон улсын туршлагаас харахад, сайн дурын ажилтнуудын оролцоо нь хоригдлуудын нийгэмшил, суллагдсаны дараах амьдралд амжилттай шилжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний оролцоо нь хоригдлуудын боловсрол, сэтгэл зүй, харилцааны ур чадвар, нийгэмд оролцоог нэмэгдүүлдэг. Иймд Монгол Улсад хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэхэд сайн дурын ажилтнуудын оролцоог дэмжих, зохион байгуулах нь чухал юм.

Сайн дурынхны сургалт: Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэхэд сайн дурын ажилтнуудыг мэргэжлийн түвшинд бэлтгэх сургалтууд зохион байгуулах. Сургалтууд нь сэтгэл зүй, ёс зүй, нийгэмд оролцооны чиглэлээр төвлөрч, хоригдлуудтай хамтран ажиллах ур чадвар

эзэмшүүлэх хэрэгтэй. Түүнчлэн, энэ сургалтын хөтөлбөрт хоригдол, түүний гэр бүлийн сэтгэл зүйн онцлогийг ойлгож, тэдэнд хэрхэн туслах талаар зааварчилгаа өгөх шаардлагатай.

Хамтын ажиллагааны сүлжээ үүсгэх: Сайн дурын ажилтнуудын оролцоог зөвхөн хорих байгууллагын хүрээнд бус, олон нийт, төрийн бус байгууллагууд, нийгмийн үйлчилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь үр дүнтэй. Энэ нь нийгмийн сүлжээг бий болгож, хоригдлын суллагдсаны дараах шилжилтэд дэмжлэг үзүүлнэ.

ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь хоригдлыг суллагдахад бэлтгэх үйл явц, нийгэмшүүлэх үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь сайн дурын ажилтнуудын оролцоо юм. Олон улсын жишгээр, сайн дурын ажилтнуудын оролцоотой хөтөлбөрүүд нь хоригдлуудын боловсрол, сэтгэл зүй, нийгэмд оролцоог нэмэгдүүлж, суллагдсаны дараа нийгэмд амжилттай дасан зохицох боломжийг бүрдүүлдэг. Энэ нь зөвхөн тухайн хоригдлын хувь хүний түвшинд төдийгүй нийгмийн тогтвортой байдал, аюулгүй байдалд ч эерэг нөлөө үзүүлдэг.

Монгол Улсын холбогдох эрх зүйн орчинд хоригдлыг нийгэмшүүлэхэд сайн дурын ажилтнуудын оролцоо хязгаарлагдмал байгааг хэлэх хэрэгтэй. Хэдийгээр зарим хууль, журамд сайн дурынхны оролцоог хүлээн зөвшөөрөх боломж байгаа ч, тэдний оролцоог зохицуулах, дэмжих эрх зүйн хүрээ нэмэгдэж, тодорхой, ил тод байх шаардлагатай. Тусгай зохицуулалтууд болон хорих ангийн дотоод журмуудад сайн дурын ажилтнуудын оролцоог тодорхой зааж өгөх нь хоригдлын нийгэмшүүлэх ажлыг илүү үр дүнтэй, амжилттай болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сайн дурын ажилтнуудын оролцоо нь хоригдлуудын зан үйлд эерэг өөрчлөлт авчрах, тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх, суллагдсаны дараа нийгэмд амжилттай дасан зохицох боломжийг бий болгох, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх гол хүчин зүйл болж чадна. Иймээс, Монгол Улсад хоригдлыг суллагдахад бэлтгэх үйл явцад сайн дурын ажилтнуудын оролцоог дэмжих, зохион байгуулах нь нийгмийн зөв тогтолцоог бүрдүүлэх, хуулийн засаглалын тогтвортой байдлыг хангах чухал алхам болно. Мөн сайн дурынхны оролцоог хууль, журам, зохицуулалттай уялдуулан хөгжүүлэх нь Монгол Улсын шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тогтолцооны үр дүнг дээшлүүлэх, хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлд амжилт оруулах гол үндэс болох юм.

Сайн дурын ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх нь хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний оролцоог хууль эрх зүйн хүрээнд зохицуулж, арга зүйн хүрээнд зөв удирдлагаар хангаж, нийгмийн олон байгууллагаас дэмжлэг үзүүлснээр хоригдлуудын амжилттай нийгэмд дасан зохицох боломжийг бий болгож, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал алхам болно.

САНАЛ

Сайн дурын ажилтнуудыг хоригдлыг суллах, нийгэмшүүлэх үйл явцад оролцуулах нь нийгмийн халамж, хүмүүнлэгийн үүднээс чухал ач холбогдолтой гэдгийг дүгнэж, дараах саналыг боловсрууллаа. Үүнд:

Хууль эрх зүйн хүрээнд:

Хуульд өөрчлөлт оруулах: Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль, хорих ангийн дотоод журамд сайн дурын ажилтнуудын оролцоог тодорхой зааж, тэдний үүрэг, хариуцлагыг хуульчилж өгөх шаардлагатай. Сайн дурынхны оролцоог хэрэгжүүлэх, тэднийг зохицуулах хуулийн заалтууд нь шударга, ил тод, аюулгүй байдлыг хангах үндэс болно.

Тусгай журам батлах: Сайн дурын ажилтнуудын оролцоог хангах, үр дүнтэй зохион байгуулах журмыг боловсруулан, хоригдлын нийгэмшүүлэх, суллагдах үйл явцад сайн дурын оролцоог хамгийн сайн хувилбараар ашиглах арга зүйн хүрээнд тусгах хэрэгтэй.

Сайн дурын ажилтнуудын эрх зүйн хамгаалалт: Сайн дурын ажилтнуудын эрх зүйн хамгаалалтыг сайжруулах, ажиллаж байгаа хугацаанд нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, аюулгүй байдал, хуулийн хамгаалалт зэрэгт тавигдах шаардлагуудыг хуульд тусгах нь чухал. Энэ нь сайн дурын ажилтнуудын үүрэг, хариуцлагыг хамгаалах, тэдний оролцоог өргөжүүлэхэд дэмжлэг болно.

Арга зүйн хүрээнд:

Сайн дурын ажилтны сэтгэл зүй, амьдралын ур чадварын сургалт: Хоригдлуудтай хамтран ажиллах сайн дурын ажилтнуудын сэтгэл зүй, харилцааны ур чадварыг сайжруулах сургалтуудыг зохион байгуулж, сэтгэл зүйн дэмжлэг, харилцан итгэлцэлтэй ажиллахад бэлтгэх нь чухал.

Нийгмийн хүрээнд:

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх: Нийгмийн бүх давхарга, төрийн бус байгууллагуудыг сайн дурын хөдөлгөөнд татан оролцуулах шаардлагатай. Энэ нь хоригдлуудын нийгэмд орох боломжийг нэмэгдүүлэх, тэдний дэмжлэгийг чухал болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх болно.

Сайн дурынхны хөдөлгөөнийг дэмжих: Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тусгай хөтөлбөрүүд, урамшууллын систем боловсруулан, тэдний оролцоог өөгшүүлэх, дэмжих нь чухал. Мөн олон нийтийн мэдээллийн кампанит ажлуудыг хэрэгжүүлж, сайн дурынхны үүргийг тодорхойлж, нийгэмд тэдний оролцоог чухал гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх: Төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, эрүүл мэндийн салбар зэрэг нь сайн дурын ажилтнуудын дэмжлэгийг авч, хоригдлын нийгэмшүүлэх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх боломжтой. Төрийн байгууллагууд нь хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход оролцож, хувийн хэвшлийн байгууллагууд ажлын байр олгох, хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлж болно.

Техникийн болон логистикийн хүрээнд:

Технологи ашиглах: Хоригдлыг нийгэмшүүлэх үйл явцад шинэ технологи, программ хангамж ашиглах нь сайн дурын оролцоог нэмэгдүүлэх нэг арга юм. Тухайлбал, цахим сургалт, видео зөвлөгөө, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх онлайн платформуудыг ашиглан сайн дурын ажилтнуудын оролцоог уялдуулж болно.

Логистикийн дэмжлэг: Сайн дурын ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэхэд шаардлагатай логистикийн дэмжлэг, материаллаг нөөцийг шийдвэрлэх нь чухал. Тухайлбал, газар дээрх зохион байгуулалт, бэлтгэл сургалт, эдийн засгийн дэмжлэгийг бий болгох хэрэгтэй.

Сайн дурын ажилтнуудын сонирхол, урамшуулал:

Урамшууллын тогтолцоо бий болгох: Сайн дурын ажилтнуудад тухайн үүрэгт ажиллах хугацаанд урамшуулал, танилцуулга, талархал илэрхийлэх системийг бий болгох нь тэдний оролцоог үр дүнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Нийгмийн хүлээн зөвшөөрөлт: Сайн дурын ажилтнуудын оролцоог нийгэмд илүү түгээж, тэднийг үнэлэх, талархах системийг бий болгох нь хүмүүсийн сайн дурын хөдөлгөөнд оролцох сонирхлыг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж

asia.yokkao.com. (2025). asia.yokkao.com.

<https://canine.org/news/>. (2023). <https://canine.org/news/>. Retrieved from <https://canine.org/news/>.

<https://www.cep-probation.org/projects/>. (2025). <https://www.cep-probation.org/projects/>.

<https://www.prisonfellowship.org/>. (2024). <https://www.prisonfellowship.org/>. Retrieved from <https://www.prisonfellowship.org/>.

insideoutcenter.org. (2023). insideoutcenter.org.

Singapore, Y. R. (2024). Yellow Ribbon Singapore. Retrieved from Yellow Ribbon Singapore .

www.artofliving.org. (2024). www.artofliving.org. Retrieved from www.artofliving.org.

www.csd.gov.hk. (2022). www.csd.gov.hk. Retrieved from www.csd.gov.hk.

ажил, С. д. (2024). <https://mn.wikipedia.org/>. Retrieved from <https://mn.wikipedia.org/>.

Г.Золжаргалан, С. (2023). Залуучуудын дундах хүчирхийлэл урьдчилан сэргийлэх онол, арга зүй . Улаанбаатар : Тотопресс .